



**ХЭНТИЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ**

2023 оны 07 сарын 03 өдөр

Дугаар 5/94

Хэрлэн сум

**Г.Ариунхүүг түр орлон
гүйцэтгэгчээр томилох тухай**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5, 67.4, Төрийн албаны тухай хуулийн 43 дугаар зүйлийн 43.2, 43.3.4 дэх заалт, Засгийн газрын 2019 оны 'Төрийн жинхэнэ албан хаагчийн албан үүргийг түр орлон гүйцэтгэхэд цалин, урамшуулал олгох журам'-ын 9 дүгээр хавсралтын 2.3 дах заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Төсвийн зарлага хариуцсан мэргэжилтэн нь жирэмсний болон амаржсаны амралттай байгаа тул Санхүү, төрийн сангийн хэлтсийн Бүртгэлийн мэргэжилтэн Гүрцэдэнгийн Ариунхүүг түр орлон гүйцэтгэгчээр 2023 оны 7 дугаар сарын 03-ны өдрөөс эхлэн томилсугай.

2.Г.Ариунхүүгийн ажлыг хүлээлцүүлэх комиссыг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Комиссын

дарга: Д.Нямдаваа: Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга

Гишүүд: Д.Цэцэгсүрэн: Санхүү, төрийн сангийн хэлтсийн аймгийн Төсвийн ерөнхийлөн Захирагчийн Төсвийн ерөнхий нягтлан бодогч

Э.Ариунтунгалаг: Аймгийн Засаг даргын Тамгын газрын Нягтлан бодогч

Д.Энхтуяа: Архив, бичиг хэргийн эрхлэгч

Т.Баяртуяа: Аймгийн Засаг даргын Тамгын газрын Нярав

3.Г.Ариунхүүгийн түр орлон гүйцэтгэх хугацаа нь 6 сараас дээш үргэлжлэх тул албан тушаалын цалингийн 40 хүртэлх хувиар тус тус тооцож олгохыг Нягтлан бодогч (Э.Ариунтунгалаг)-д үүрэг болгосугай.

4.Төрийн албаны тухай хууль болон холбогдох хууль тогтоомж, тогтоолын шийдвэр, байгууллагын дотоод журам, албан тушаалын тодорхойлолтод заагдсан чиг үүргийг хэрэгжүүлж ажиллахыг Г.Ариунхүүд үүрэг болгосугай.

ДАРГЫН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН
ГҮЙЦЭТГЭГЧ

Ж.ГАНТУЛГА



D:\My Documents\ Тушаал-2023

231 030256